

Та бүхэнд санхүүгээ зөв удирдах **5 ЧУХАЛ ДАДАЛ**, мөн санхүүгийн хувьд хүмүүсийн түгээмэл гаргадаг **5 АЛДААГ** танилцуулъя.




## САНХҮҮГЭЭ ЗӨВ УДИРДАХ 5 ДАДАЛ

### Мөнгөн урсгалаа бүртгэх



Орлого, зарлагаа тогтмол бүртгэж, санхүүгийн урсгалаа хянах.

### Төлөвлөж худалдан авалт хийх



Том худалдан авалт хийхээс өмнө **24-48 цаг** бодож шийдвэр гаргах.

### Жижиг зардлаа хязгаарлах



Өдөр, долоо хоногт зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох.

### Автомат шилжүүлэг ашиглах



Тогтмол зардал ба хадгаламжийг автоматаар татах тохиргоо хийх.

### Нэмэлт орлогын хуваарилалт



Бонус, бэлэг зэрэг нэмэлт орлогыг хөрөнгө оруулалт, гэнэтийн хэрэгцээнд зориулж хуримтлал хийх.

# САНХҮҮГЭЭ УДИРДАХАД ГАРГАДАГ ТҮГЭЭМЭЛ 5 АЛДАА

## Төлөвлөлтгүй худалдан авалт



Хэрэгцээгүй зүйлсийг сэтгэл хөдлөлөөр эсвэл “шинэ загвар”, “хямдрал” зарласан гэх шалтгаанаар худалдан авалт хийх.

## Хуримтлал үүсгэхээс зайлсхийх



“Дараа хадгална” гэж байнга хойшлуулах, орлогоос үлдсэнийг хадгална гэж төлөвлөх.

## Өрийн дарамтад орох



Зээлийг анх авсан зорилгоос өөр зүйлд (хэрэгцээгүй худалдан авалт, зугаа, тансаг хэрэглээ) зарцуулах, нэмж зээл авах.

## Жижиг зардлыг үл тоох



Өдөр тутам давтагддаг гардаг жижиг зардлуудыг анзаарахгүй өнгөрөөх. Жишээлбэл, кофе, такси, амттан, аппликейшны захиалга.

## Хүсэл ба хэрэгцээг ялгахгүй байх



Зайлшгүй хэрэгцээнээс илүү, түр зуурын хүсэл болон трендийг бодит хэрэгцээтэй андуурч худалдан авалт хийх.